



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2022 оны 02 сарын 14 өдөр

Дугаар А/56

Арвайхээр

Уралдаан зарлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 14.2.10, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 03/03 дугаар тогтоолоор батлагдсан “Өвөрхангай аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 3.2.1.8, 3.3.2.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний төсөвт байгууллагууд, орон нутгийн өмчит хуулийн этгээдүүдийн хооронд зарлагдах “Дотоод хяналтыг төлөвшүүлэх” уралдааны удирдамжийг хавсралт ёсоор баталсугай.

2.Удирдамжийн хэрэгжилтийг хангуулах, мэргэжил арга зүйгээр хангах хяналт тавьж, дүгнэж ажиллахыг Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны дарга (М.Эрдэнэчулуун), аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Ц.Идэрсайхан) нарт тус тус даалгасугай.

3.Уралдааныг жилийн эцэст дүгнэж хамгийн өндөр үнэлгээ авсан нэг байгууллагыг шалгаруулж 500,000 (таван зуун мянга) төгрөгөөр шагнасугай.

4.Шагналын зардлыг аймгийн Засаг даргын хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Ц.Идэрсайхан)-д зөвшөөрсүгэй.


ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

6222 11 0117

Аймгийн Засаг даргын 2022 оны  
 03 дугаар сарын 01-ны өдрийн  
 4756 дугаар захирамжийн  
 хавсралт



## УДИРДАМЖ

### Дотоод хяналтыг төлөвшүүлэх уралдааны тухай

Зорилго: Засгийн газрын 2011 оны 11 дүгээр сарын 09-ны өдрийн 311 дүгээр тогтоол, батлагдсан “Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам”-ын хэрэгжилтийг сайжруулах, улсын салбарын дотоод хяналтыг төлөвшүүлэх, дотоод хяналтын нэгжийн үйл ажиллагааг идэвхижүүлэх, мэргэшүүлэх, чанаржуулах, дотоод аудитын байгууллагатай харилцах харилцааг сайжруулахад энэ аяны зорилго оршино.

Хамрах хүрээ: Хавсралт дахь нэр бүхий аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний төсөвт байгууллага, орон нутгийн өмчит компани

Хэрэгжих хугацаа: 2022 оны 03 дугаар сарын 01-ний өдрөөс 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн хооронд

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

Д/д	Арга хэмжээ	Хугацаа	Хэрэгжүүлэгч	Шалгуур
1	Хамрах хүрээний байгууллагуудад эрсдэлийн удирдлага, дотоод хяналтын чиглэлээр сургалт хийх, зөвлөгөө өгөх	1 дүгээр улиралд	Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба	-
2	Байгууллагын эрсдэлийн үнэлгээ хийх, нэгтгэн дүгнэх аргачлал боловсруулан байгууллагуудад тараах	1 дүгээр улиралд	Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба	-
3	Байгууллагын эрсдэлийг тодорхойлох, бүртгэлжүүлэх, үнэлгээ хийх	1 дүгээр улиралд		Тодорхойлсон эрсдэл нь байгууллагын үйл ажиллагааг бүхэлд нь хамарсан байх, байгууллагын зорилго, зорилтод чиглэсэн байх, эрсдэлийг зөв томъёолсон байх, үнэлгээг бодитой үнэн зөв хийсэн байх
4	Эрсдэлийн төлөвлөгөө эсрэг ажиллах гарган	2,4 дүгээр улиралд	Хамрах хүрээний байгууллагууд	Төлөвлөгөө нь хэрэгжихүйц бодитой байх, хэрэгжүүлэх арга хэмжээг эрэмбэлсэн байх
5	Эрсдэлд суурилсан дотоод хяналтын төлөвлөгөө гарган хэрэгжүүлэх	2,4 дүгээр улиралд		Төлөвлөгөө нь байгууллагын үйл ажиллагааг сайжруулах, зөрчлийг илрүүлэх, эрсдэлээс урьдчилсан

				сэргийлэхэд чиглэсэн байх төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн бодитой гарсан байх
6	Дотоод хяналтын зураглал хийх	2,4 дүгээр улиралд		Дотоод хяналтын зураглал нь ойлгомжтой, хийдэл, давхардалгүй байх
7	"Дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журам"-ыг өөрийн байгууллагын онцлогт тохируулан боловсруулан шинэчилж, баталж, мөрдөх	2 дугаар улиралд		Өөрийн байгууллагын онцлогт тохирсон байх, гол асуудлыг тусгасан ойлгомжтой, хэрэгжүүлэх боломжтой байх
8	Сумын Засаг даргын дэргэд сумын нэгдсэн дотоод хяналтын нэгжийг байгуулж харьяа байгууллагуудын үйл ажиллагаанд дотоод хяналтыг хийх		Сумдын Засаг дарга нар	Харьяа байгууллагуудад жилд 1-с доошгүй удаа дотоод хяналт хийж, илэрсэн асуудлыг шийдвэрлэсэн байх
9	Хийсэн ажлын тайланг 2023 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн дотор Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанд нэгтгүүлэх		Хамрах хүрээний байгууллагууд	Санхүүгийн хяналт аудитын албанаас гаргасан маягтын дагуу

Уралдааныг дүгнэх: Уралдааныг 2023 оны 1 дүгээр сард дүгнэнэ.

Уралдаан дүгнэх үзүүлэлт:

Үзүүлэлт	Нэмэлт шалгуур
1.Хэрэгжүүлэх арга хэмжээ тус бүрийг харгалзах шалгуурт нийцэж байгааг дүгнэх	- Байгууллагын үйл ажиллагаа сайжирсан байх, ахиц дэвшил гаргасан байх
2.2022 оны үйл ажиллагаанд хийсэн Хяналт шинжилгээ үнэлгээний дүнг харгалзах	- Эрсдэл буурсан байх - Уралдаанд идэвх санаачилгатай оролцсон байх
3.Хяналт шалгалтын байгууллагуудаас өгсөн дүгнэлтийг харгалзах	- Шинэ санал санаачилга гаргасан байх

Уралдааны болзол: Хамгийн сайн үнэлэгдсэн 1 байгууллагыг 500,000 төгрөгөөр шагнах, сайн туршлагыг алдаршуулах, түгээх